

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

04.06 - 04.10



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Сүүлийн үеийн мэдээгээр, коронавирусын тархалт болон эмнэлгийн тоо баримтууд эерэг гарж байгаатай холбоотой АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа. S&P500 индексийн сагсанд багтах эрчим хүчний болон санхүүгийн салбарын компаниуд хамгийн их өсөлттэй байлаа. Баасан гарагт амралтын өдөр байсантай холбоотой АНУ-ын хөрөнгийн зах зээл хаалттай байлаа.

Итали, Франц, Герман, Испани болон Нью-Йорк хот зэрэг коронавирус илүүтэйгээр тархаж байсан газруудад шинээр халдвар авагсдын тоо буурч эхэлсэн нь энэ долоо хоногийн эхэнд зах зээл өсөлт үзүүлэхэд нөлөөлжээ. Цаашлаад, Мягмар гарагт БНХАУ-ын коронавирусээр нар барсан тохиолдол бүргэгдээгүй, Германы эдгэрч байгаа хүмүүсийн тоо нь шинээр халдвар авагсдын тооноос давсан ба Итали хөл хориогоо 05-р сарын 04-ны өдөр цуцлахаар болсон зэрэг мэдээнүүд зах зээлд эергээр нөлөөлсөн байна. Хэдийгээр Нью-Йорк хотын коронавирусээр нас барагсдын тоо Мягмар, Лхагва гарагуудад оргил цэгтээ хүрсэн ч хөрөнгө оруулагчид шинээр өвчлөгсдийн тоо буурч байгааг илүү сайнаар хүлээж авсан байна. Вашингтоны Их Сургуулийн загвар АНУ-ын нийт коронавирусээр нас барагчдын тоог бууруулан таамаглаж байгаагаа мэдэгджээ.

Европ: Европт коронавирусээр нас барсан тохиолдлын тоо үхлийн тоо буурч байгаа нь хөл хорио удахгүй тавигдана гэсэн найдлагыг төрүүлж, хөрөнгийн зах зээл өсөлттэй байхад нөлөөлсөн байна. STOXX Europe 600 индекс 6.62%, DAX индекс 11%, CAC 40 индекс 7.62%, FTSE MIB индекс 5% болон FTSE 100 индекс 7.89% тус тус өссөн байна.

Пүрэв гарагт Евро группийн санхүүгийн сайд нар коронавирусын цар тахлын улмаас эдийн засгийн хүнд байдалд ороод байгаа бүс нутгуудыг дэмжих хөтөлбөрийг батлах талаар хуралдсан байна. Хэдийгээр хурал 16 цаг үргэлжилсэн хэдий ч тодорхой зөвшилцөлд хүрээгүй байна. ХБНГУ тус саналд татгалзсан хариу өгч байгаа ба Нидерланд улс Европын Тогтворжуулалтын Механизм (European Stability Mechanism)-ыг ямар нэг болзолгүйгээр хэрэгжүүлэхийг эсэргүүцэж байгаа аж. Харин Франц, Италийн хувьд нэгдмэл бонд гаргаж, тус санхүүжилтээр хамгийн их өрөнд ороод байгаа улсуудад дэмжлэг үзүүлэхийг зорьж байна.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт өсөлттэй хаагдлаа. Nikkei 225 Stock Average индекс 9.42%-аар өсөж 19,498.50 хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.2%-аар бага байна. Large-cap TOPIX болон TOPIX Small индексүүд аль аль нь өсөлттэй байсан боловч, өмнөх оны мөн үеэс 17.7% болон 22.0%-аар харьцангуй бага байна. Энэ долоо хоногийн хувьд иений ханш суларч, Пүрэв гарагт нэг доллар 109 иентэй тэнцүү болсон байна.

БНХАУ: Чинг Минг амралтын өдрөөр (Ching Ming holiday) Даваа гарагт Хятадын зах зээл хаалттай байлаа. Харин Мягмар гарагт дэлхий нийтээр коронавирусын үзүүлэлтүүд буурсантай холбоотойгоор Хятадын зах зээл өсөлттэй нээгдсэн байна. Өнгөрсөн долоо хоногийн Баасан гарагаас энэ долоо хоногийн Пүрэв гараг хүртэл Shanghai Composite индекс болон CSI 300 индекс аль аль нь 2.2% орчим өсөлт үзүүлсэн байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	16,824.10	-0.51% ▼
Dow Jones	АНУ	23,719.37	12.67% ▲
S&P 500	АНУ	2,789.82	12.10% ▲
Nasdaq	АНУ	8,153.58	10.59% ▲
S&P/TSX	Канад	14,166.63	9.49% ▲
FTSE 100	Их Британи	5,842.66	7.89% ▲
S&P/ASX 200	Австрали	5,387.30	6.31% ▲
Nikkei 225	Япон	19,498.50	9.42% ▲
Hang Seng	Хонг Конг	24,300.33	4.38% ▲

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	96.01
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	91.83
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	91.73
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	100.41
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	102.17
DBM' 2023	USD	7.250%	88.68
TDBM' 2020	USD	9.375%	99.83
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	79.79

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.814	-0.17 ▼
Libor 3M	1.219	-0.17 ▼
Libor 6M	1.226	0.02 ▲
Libor 1YR	1.051	0.00 ▲
US 2YR Bond	0.224	-0.01 ▼
US 3YR Bond	0.295	-0.02 ▼
US 5YR Bond	0.409	0.01 ▲
US 10YR Bond	0.727	0.10 ▲

Валютын ханш	2020.04.10	Өөрчлөлт
USD	2,781.94	0.08% ▲
CNY	395.40	0.90% ▲
EUR	3,044.56	1.45% ▲
RUB	37.71	4.69% ▲
KRW	2.30	1.77% ▲
JPY	25.67	-0.08% ▼
CAD	1,993.79	1.57% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,696.65	4.68% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	15.57	8.18% ▲
Зэс	USD/lb.	225.95	3.06% ▲
Нүүрс	USD/MT	60.96	-4.48% ▼
WTI газрын тос	USD/bbl.	22.76	-19.69% ▼
Brent газрын тос	USD/bbl.	31.48	-7.71% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020. II	6.4%
Бодлогын хүү	2020. II	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020. II	10.95 %
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020. II	11.33%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020. II	4.71%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020. II	17.01%
Зээлийн дундаж хүү /валют/	2020. II	10.35%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 38 компанийн 185.1 сая төгрөгийн 1,610,552 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Лэндмн ББСБ” /LEND/ компанийн хувьцаа 22.23%-аар буюу хамгийн ихээр өсөж 37.88 төгрөг хүрч хаагдсан бол “Гутал” /GTL/ компанийн хувьцаа 15.69%-аар буурч 17,200.00 төгрөгт хүрч хаагдлаа.


Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

04-р сарын 10-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,462.1 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 16,824.10 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.51%-аар буурсан байна.

MSE Индекс



Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2020 он/



Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	185,1	
Зах зээлийн үнэлгээ	2,462,053.9	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	16,824.10	-0.51% ▼
MSE I индекс	7,816.60	-0.26% ▼
MSE II индекс	7,623.07	0.55% ▲

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Ард санхүүгийн нэгдэл	26,772	40,231,633
АПУ	65,465	35,164,024
Лэндмн ББСБ	830,751	28,348,235
Говь	119,593	20,692,535
Мандал даатгал	341,627	15,462,038

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Лэндмн ББСБ	37.88	22.23% ▲
Хөсөг трейд	2,242.00	14.97% ▲
Жуулчин дютти фрий	73,550.00	13.15% ▲
Шарын гол	1,150.00	12.20% ▲
БиДиСек	896.00	11.72% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Гутал	17,200.00	-15.69% ▼
Таван толгой	5,255.00	-12.42% ▼
Махимпекс	2,360.00	-8.17% ▼
УБ-БҮК	419.99	-6.67% ▼
Улсын их дэлгүүр	1,160.00	-6.22% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Ард Секюритиз	102,667,222
Дархан Брокер	62,588,155
БиДиСек	42,388,376
Стандарт Инвестмент	35,798,246
Голомт Капитал	25,637,245

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	ЗЗҮ (сая.төг)
АПУ	540.18	574,850
Таван толгой	5,255.00	276,756
МИК Холдинг	11,910.00	246,648
Инвексор ББСБ	2,490.00	178,603
Говь	185.09	144,391

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.08.31-НИЙ ДОТОР
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.30-НЫ ДОТОР
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НЫ ӨДӨР
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.30-НЫ ДОТОР
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	715.9	1,000.0	139.7%	35.0	2020.04.07	2020.04.30-НЫ ДОТОР
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.24-НЫ ӨДӨР
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.06.01-ЭЭС
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХУНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.05.01-ЭЭС
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.03.15-ААС
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.06.30-НЫ ДОТОР
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.01-НИЙ ДОТОР
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.05.01-ААС 2020.05.15-НЫ ХООРОНД
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.08.01-НИЙ ДОТОР
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.01-ЭЭС
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ



Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй “Дижитал шилжилт” хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллагын үйлчилгээг цахимжуулах бодлого, стратегийг боловсруулж, шат дараалсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Санхүүгийн зохицуулах хороо энэ ажилд өндөр ач холбогдол өгч, манлайлан хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг хялбаршуулах, иргэд үйлчлүүлэгчдэд шуурхай хүргэх, үйлчилгээний ил тод байдлыг хангах, улмаар төрийн үйлчилгээн дэх хүнд суртлыг арилгах, төвлөрлийг сааруулах зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор цахимаар өргөдөл, гомдол хүлээн авах болон “Зөвшөөрлийн цахим систем”-ийг нэвтрүүлээ.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

“Баянтээг” ХК ногдол ашиг тараахаар боллоо

“Баянтээг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 04-р сарын 03-ны өдрийн №10 тоот тогтоолоор 2019 оны цэвэр ашгийн 23.08% буюу нэгж хувьцаандаа 1,979.3 төгрөг, нийт 500 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тараахаар болов.

Энэхүү ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоох бөгөөд 2020 оны 12-р сарын 01-ний өдөр “ҮЦТХТ” ТӨХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэв.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Дараах хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурал цахим хэлбэрээр зохион байгуулагдана

Covid-19-ийн халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор 04-р сарын 10-ны байдлаар дараах хувьцаат компаниуд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар хийхээр шийдвэрлэсэн байна Үүнд:

- “Инвескор ББСБ” ХК
- “АПУ” ХК
- “Мандал даатгал” ХК
- “Би Ди Сек ҮЦК” ХК
- “Түмэн шувуут” ХК
- “Монос хүнс” ХК
- “Сүү” ХК
- “МИК холдинг” ХК
- “Техник импорт” ХК
- “Хөх ган” ХК
- “Женко тур бюро” ХК
- “Э-Транс ложистикс” ХК
- “Гутал” ХК

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

2019 онд “Монголын цахилгаан холбоо” ХК үндсэн зардлаа бууруулж, нэг тэрбум төгрөг хэмнэжээ

2019 онд “Монголын цахилгаан холбоо” ХК үндсэн зардлаа 20-35 хувь хүртэл бууруулж, нэг тэрбум төгрөг хэмнэснээ үйл ажиллагааныхаа тайланд онцолжээ.

Үүнд интернэтийн бөөний урсгал болон хот хоорондын дамжуулах сүлжээний үйлчилгээ авч буй компаниудтай гэрээний нөхцөлөө шинэчлэн ажилласан нь нөлөөлсөн байна. Тайлант хугацаанд тус компани БНСУ-ын “Korea Telecom”, АНУ-ын “AT&T”, БНХАУ-ын “China Unicom” зэрэг компанитай хамтран хэрэглэгчдэд дэлхийн 160 гаруй улс руу шууд гарцаар олон улсын ярианы үйлчилгээ үзүүлжээ.

2019 онд тус компанийн борлуулалтын орлого 7.6 хувиар өсөж, 15.4 тэрбум төгрөг болсон байна. “Монгол шуудан” ХК өнгөрсөн оны долоодугаар сараас ОХУ-ын “Почта России” компанитай хамтарч, БНХАУ-аас ОХУ руу чиглэсэн шуудан илгээмжийг Монгол Улсаар дамжуулан өнгөрүүлэх хамтын ажиллагааг дахин эхлүүлснээ үйл ажиллагааныхаа тайланд онцоллоо.

Тайлант хугацаанд шуудангийн гадаад, дотоод нийт солилцоо өмнөх жилээс 15.25 хувиар өсөж, 2.6 сая болсон боловч дамжуулан өнгөрүүлсэн транзит шуудан 2.1 сая ширхэг байсан нь өмнөх оноос 29 хувиар буурсан үзүүлэлт болсныг тус компани тайландаа дурджээ.


Эх сурвалж: BloombergTV.mn

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Гашуунсухайт боомтын нүүрсний экспорт ердийн үеийнхээс бага байгаа боловч гол экспортлогчдын нэг "Тавантолгой" ХК бүрэн хүчин чадлаараа ажиллаж байгаагаа мэдэгдлээ. Тус компани 2020 онд зургаан сая тонн нүүрс экспортлохор төлөвлөж байсан боловч одоо нөхцөл байдал хэвийн үеийнх шигээ сэргэхгүй байгаа учир төлөвлөгөө нь тасалдаж байгааг тус компанийн Гүйцэтгэх захирал Р.Сэддорж мэдээллээ. Экспорт хэвийн үргэлжлэхгүй, орлого тасалдаж байгаа нь хувьцааны ханш буурахад нөлөөлж байна гэж үзэж байна.

Эх сурвалж: BloombergTV.mn



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

"Bloomberg Economics"-ийн тооцоолсноор БНХАУ-ын ихэнх хэсэгт өнгөрсөн 7 хоногийн төгсгөл гэхэд байгууллагууд болон бизнесүүдийн 90-95 хувь нь хэвийн горимдоо шилжсэн байна.

Коронавирусийн тархалтын улмаас доголдоод байсан эдийн засаг эргэн хэвийн байдалд шилжих дөхөж байгааг БНХАУ-д түүхий эдийн хэрэглээ эргэн нэмэгдэж байгаагаас харж болохоор байгаа юм. Жишээ нь: бие дааж үйл ажиллагаа явуулдаг газрын тос боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагааны идэвх III сард огцом буурсан бол өнөөдөр эргэн дээшилж өмнө нь байгаагүй өндөр цэгт дөхсөн байна. Өнгөрсөн сард өдөрт 12 сая баррель тос боловсруулж байсан бол энэ сард 13 сая баррельд хүрэхээр байна. Харин нүүрсний хэрэглээний тухайд БНХАУ-ын цахилгаан станцууд IV сарын 7-ны өдрийн байдлаар 2019 оны мөн үеийнхтэй бараг ижил хэмжээний нүүрс хэрэглэж байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

"COVID-19"-ийн тархалтаас сэргийлж нүүрсний экспортыг зогсоосон нь "Mongolia Energy Corporation"-ийн I, II улирлын борлуулалт, бэлэн мөнгөний урсгалд сөргөөр нөлөөлнө гэдгийг тус компани мэдэгдлээ.

Санхүүгийн сөрөг үр дагаврыг бууруулахын тулд тус компани уурхайн гол үйл ажиллагаануудаа зогсоож, зарим ажилчдадаа чөлөө өгсөн байна. Экспорт эхэлсэн ч эхэн үедээ бага хэмжээтэй байх төлөвтэй гэж үзжээ.

Эх сурвалж: BloombergTV.mn



МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.